



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 9/158

Хэрлэн сум

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 313 дугаартай “Дүрэм батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Бласттек” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, агуулахын газрын байнгын байршилыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг мөрдөж, стандартын дагуу тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг “Бласттек” ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршилыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ), Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Батхүү)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023

231010423

Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 17-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

“Бласттек” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн  
үйлдвэр, агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	109	27	38	46	14	44
2	109	27	34.5	46	14	40
3	109	27	24	46	14	43
4	109	27	27	46	14	47